



СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 15 сарын 10 өдөр

Дугаар А/10

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Хэмжил зүйн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.8 дахь заалт, Стандарт, хэмжил зүйн газрын даргын зөвлөлийн 2021 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Улсын шалгагчийн эрх олгох, түүнийг аттестатчилах журам"-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Тамгын газар /Б.Эрдэнэзул/, Хэмжил зүйн хүрээлэн /Д.Дамбасүрэн/, Хэмжих хэрэгслийн шалгалт, баталгаажуулалтын газар /Л.Баярхүү/, Стандартын сургалт, мэдээллийн үндэсний төв /Ч.Хатанбаатар/, аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга нарт, хяналт тавьж ажиллахыг Стратегийн бодлого төлөвлөлт, дотоод аудитын газар /Б.Ууганбаяр/-т тус тус даалгасугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Стандартчилал, хэмжил зүйн газрын даргын 2014 оны А/100 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


ДАРГА



Б.БИЛГҮҮН

028028886

Стандарт, хэмжил зүйн газрын даргын
2021 оны . 11 дугаар сарын 10 -ны
өдрийн А.Ю. дүгээр тушаалын хавсралт



УЛСЫН ШАЛГАГЧИЙН ЭРХ ОЛГОХ, ТҮҮНИЙГ АТТЕСТАТЧИЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Хэмжил зүйн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан үйл ажиллагаанд ашиглах хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын ажлыг гүйцэтгэх хэмжүүрийн улсын шалгагчид тавих ерөнхий шаардлагыг тогтоох, эрх олгох, цуцлах, түдгэлзүүлэх, сэргээх, түүнийг аттестатчилах үйл ажиллагааг энэ журмаар зохицуулна.

1.2 Улсын шалгагчийн аттестатчилал гэдэг нь улсын шалгагчийн хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтын ажлыг гүйцэтгэх хууль эрх зүй, хэмжил зүйн ерөнхий болон тухайн хэмжлийн мэдлэг, ур чадварын түвшинг Хэмжил зүйн төв байгууллагаас үнэлж, тухайн албан тушаалыг эрхлэх шаардлагыг хангаж байгааг тогтоох үйл ажиллагааг хэлнэ.

1.3 Улсын шалгагчийн аттестатчилалтай холбогдон гарах зардлыг тухайн жилийн төсөвт тусгасан байна.

1.4 Улсын шалгагчийн ажил байдлын тодорхойлолтыг нэгдүгээр, Хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын ажлын ур чадварын шалгалтын дүнгийн хуудсыг хоёрдугаар, Улсын шалгагчийн аттестатчиллын гэрчилгээний загварыг гуравдугаар, Улсын шалгагчийн эрхийг шинээр олгох шалгалтын дүнгийн хуудсыг дөрөвдүгээр, Өөр хэмжлийн төрлөөр улсын шалгагчийн эрх нэмж олгох шалгалтын дүнгийн хуудсыг тавдугаар, Улсын шалгагчдын аттестатчиллын дүнгийн хуудсыг зургаадугаар, Улсын шалгагчийн бүртгэлийг долоодугаар хавсралт маягтын дагуу тус тус гаргана.

Хоёр. Улсын шалгагчид тавигдах ерөнхий шаардлага

2.1 Улсын шалгагч нь Хэмжил зүйн төв байгууллага болон аймаг, нийслэлийн хэмжил зүйн байгууллага, салбарын хэмжигч зүйн байгууллагад хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтын ажлыг гүйцэтгэх эрхийг Хэмжил зүйн төв байгууллагаас авсан Хэмжил зүйн тухай хууль, түүнийг дагалдан гарсан дүрэм журам, тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх ажилтанг хэлнэ.

2.2 Улсын шалгагч нь MNS OIML D14 стандартын 2.3-д заасан шаардлагыг хангасан байна. Улсын шалгагч нь Хэмжил зүйн тухай хуулийн дагуу хэмжих

хэрэгслийн шалгалт баталгаажуулалтын ажлыг үндэсний стандарт, аргачлалын дагуу гүйцэтгэж, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Гурав. Улсын шалгагчийн эрх олгох

3.1 Улсын шалгагчийн эрх олгох сургалтын хөтөлбөр, мэдвэл зохих хууль тогтоомж, хэмжил зүйн ерөнхий болон тухайн хэмжлийн онолын мэдлэгийн агуулга, сэдэв, баримт бичгийн жагсаалтыг Хэмжил зүйн төв байгууллага гаргана. Сургалтын хөтөлбөр нь MNS OIML D 14 стандартын 4 дүгээр бүлэгт заасан сургалтын сэдэвчилсэн төлөвлөгөөний агуулгатай нийцсэн байна.

3.2 Хэмжил зүйн төв байгууллагаас баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу сургалтад хамрагдаж эрх олгох шалгалтад тэнцсэн ажилтанд улсын шалгагчийн эрх олгоно.

3.3 Хэмжил зүйн төв байгууллагын даргын тушаалаар улсын шалгагчийн эрх олгох ажлын хэсгийг тухай бүр томилох бөгөөд ажлын хэсэг 5-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байна.

3.4 Эрх олгох ажлын хэсгийг сургалт хариуцсан нэгжийн дарга ахлах бөгөөд гишүүд нь хэмжил зүйн салбарт тасралтгүй 5-аас доошгүй жил ажилласан, дадлага туршлагатай, мэргэшсэн ажилтан байна.

3.5 Эрх олгох ажлын хэсэг хуралдах, санал хураах, шалгалт авахад ажлын хэсгийн бүрэлдэхүүний дийлэнх олонхи нь оролцсон тохиолдолд хүчинтэй байна.

3.6 Хэмжил зүйн төв байгууллагын сургалт хариуцсан нэгж, түүний ажилтан нь улсын шалгагчийн эрх олгох үйл ажиллагаанд дараах эрх, үүрэгтэй. Үүнд:

3.6.1 Эрх олгох Сургалтын хөтөлбөрийг тухайн хэмжлийн төрлийг хариуцсан ажилтан боловсруулж, Хэмжил зүйн бодлого хариуцсан нэгжийн дарга болон Хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалт хариуцсан нэгжийн даргаар хянуулж Сургалт хариуцсан нэгжийн дарга батлах;

3.6.2 Эрх авах ажилтныг сургалтын материал, гарын авлагаар хангах;

3.6.3 Эрх олгох ажлын хэсгийг томилсон тушаалыг шалгалт авахаас ажлын 3 – аас доошгүй хоногийн өмнө гаргуулж, ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд мэдэгдэн шалгалт авах хугацааг товлож, зохион байгуулалтын бэлтгэл ажлыг хангах;

3.6.4 Эрх олгох шалгалт авсан тухай тэмдэглэл хөтлөх;

3.6.5 Шалгалтад тэнцсэн ажилтанд улсын шалгагчийн эрх олгох тухай шийдвэр үнэмлэхийг гаргуулах;

3.6.6 Эрх олгох шалгалтад тэнцээгүй ажилтанд ажлын хэсгийн дүгнэлтийг танилцуулах, дараагийн шатны үйл ажиллагааг зохион байгуулах;

3.7 Эрх олгох ажлын хэсэг дараах эрх, үүрэгтэй. Үүнд:

3.7.1 Шалгалтын тест, асуултыг бэлдэх;

3.7.2 Сургалтын хөтөлбөрт бүрэн хамрагдсан ажилтнаас онолын болон ур чадварын шалгалт авах, ярилцлага хийх;

3.7.3 Шалгалтын дүнг сургалтын асуудал хариуцсан нэгжид хүргүүлэх;

3.7.4 Шалгалттай холбоотой гомдол, маргааныг шийдвэрлэх;

3.8 Улсын шалгагчийн эрхийг шинээр олгох

3.8.1 Улсын шалгагчийн эрхийг шинээр олгох сургалтын үргэлжлэх хугацаа 230 (онол 174, дадлага 56)-аас доошгүй цаг байна.

3.8.2 Эрх шинээр авах ажилтан онолын мэдлэг, ур чадвар, ярилцлагын шалгалтыг өгөх бөгөөд доорх хэлбэрээр үнэлнэ.

Үүнд:

№	Шалгалтын хэлбэр	Шалгалтын оноо		Шалгалтад тэнцэх оноо
1	Онолын мэдлэгийн шалгалт			
	- Хууль, эрх зүйн	55 оноо	-15	9 ба түүнээс дээш
	- Хэмжил зүйн ерөнхий		-20	12 ба түүнээс дээш
	- Эрх олгох хэмжлийн		-20	12 ба түүнээс дээш
2	Ур чадварын шалгалт	35 оноо		21 оноо түүнээс дээш
3	Ярилцлага	10 оноо		
	Нийлбэр оноо	100 оноо		60 оноо, түүнээс дээш

3.8.2.1 Эрх авах ажилтан онолын мэдлэгийн шалгалтад босго онооны шаардлагыг хангасан бол мэргэжлийн ур чадварын шалгалтыг, мэргэжлийн ур чадварын шалгалтад 21 ба түүнээс дээш оноо авсан бол ярилцлагын шалгалтыг тус тус авч, дүнг журмын дөрөвдүгээр хавсралт маягтын дагуу нэгтгэн гаргана.

3.8.3 Эрх олгох ажлын хэсгийн гишүүн тус бүрийн өгсөн онооны арифметик дундажийг нэгдсэн дүнгийн хуудас дээр бичнэ.

3.8.4 Үнэлгээний нийлбэр оноог үндэслэн эрх олгох ажлын хэсэг дараах дүгнэлтийг гаргана. Үүнд:

3.8.4.1 Эрх авах ажилтан 60 ба түүнээс дээш оноо авсан бол шалгалтад тэнцсэнд тооцож, ажлын хэсгийн дүгнэлт, тэмдэглэлийг үндэслэн Хэмжил зүйн төв байгууллагын даргын тушаалаар хэмжүүрийн улсын шалгагчийн эрх олгоно.

3.8.4.2 Эрх авах ажилтан 59-өөс доош оноо авсан бол шалгалтад тэнцээгүйд тооцох ба шалгалтыг дахин 1 удаа өгч болно. Давтан шалгалтын үйл ажиллагааны зардлыг тухайн ажилтан хариуцна.

3.9 Өөр хэмжлийн төрлөөр улсын шалгагчийн эрхийг нэмж олгох

3.9.1 Улсын шалгагчид хэмжлийн өөр төрлөөр эрх нэмж олгох бол эрх олгох хэмжлийн төрлийн онолын мэдлэг, дадлагыг сургах богино хугацааны сургалтын хөтөлбөр боловсруулж батлуулах бөгөөд сургалтын үргэлжлэх хугацаа 73 (онол 17, дадлага 56)-аас доошгүй цаг байна.

3.9.2 Хэмжлийн өөр төрлөөр эрх нэмж авах ажилтан онолын мэдлэг, ур чадвар, ярилцлагын шалгалтыг өгөх бөгөөд доорх хэлбэрээр үнэлнэ. Үүнд:

№	Шалгалтын хэлбэр	Шалгалтын оноо	Шалгалтад тэнцэх оноо
1	Эрх олгох хэмжлийн онолын мэдлэгийн шалгалт	20	15 ба түүнээс дээш

2	Ур чадварын шалгалт	35	30 ба түүнээс дээш
3	Ярилцлага	10	
	Нийлбэр оноо	65	55 ба түүнээс дээш

3.9.2.1 Эрх нэмж авах улсын шалгагч нь онолын мэдлэгийн шалгалтад 15 ба түүнээс дээш оноо авсан бол мэргэжлийн ур чадварын шалгалтыг, мэргэжлийн ур чадварын шалгалтад 30 ба түүнээс дээш оноо авсан бол ярилцлагын шалгалтыг тус тус авч, дүнг журмын тавдугаар хавсралтаар баталсан маягтын дагуу нэгтгэн гаргана.

3.9.3 Эрх олгох ажлын хэсгийн гишүүн тус бүрийн өгсөн онооны дундажыг нэгдсэн дүнгийн хуудас дээр бичнэ.

3.9.4 Үнэлгээний нийлбэр оноог үндэслэн эрх олгох ажлын хэсэг дараах дүгнэлтийг гаргана. Үүнд:

3.9.4.1 Эрх нэмж авах хэмжүүрийн улсын шалгагч нь 65 ба түүнээс дээш оноо авсан бол шалгалтад тэнцсэнд тооцож, ажлын хэсгийн дүгнэлт, тэмдэглэлийг үндэслэн Хэмжил зүйн төв байгууллагын даргын тушаалаар улсын шалгагчийн эрх олгоно.

3.9.4.2 Эрх нэмж авах улсын шалгагч нь 65-аас доош оноо авсан бол шалгалтад тэнцээгүйд тооцох бөгөөд шалгалтыг 1 удаа өгч болно. Давтан шалгалттай холбогдон гарах зардлыг тухайн ажилтан өөрөө хариуцна.

3.10 Дахин шалгалтыг ажлын 10 хоногийн дотор авах бөгөөд шалгалтад тэнцсэн тохиолдолд энэ журмын 3.8.4.1, 3.9.4.1-д заасны дагуу эрхийг олгоно.

3.11 Эрх авах ажилтан болон улсын шалгагч нь дахин шалгалтад тэнцээгүй тохиолдолд ажлын хэсгийн дүгнэлт, тэмдэглэлийг үндэслэн улсын шалгагчийн эрх олгох боломжгүйг харьяалах байгууллагад нь албан ёсоор мэдэгдэнэ.

3.12 Эрх олгосон улсын шалгагчийн бүртгэлийг энэ журмын долоодугаар хавсралт маягтын дагуу хэмжил зүйн бодлогын асуудал хариуцсан нэгж хөтөлнө.

Дөрөв. Улсын шалгагчийг аттестатчилах

4.1 Улсын шалгагчийн мэдлэг, ур чадварын түвшинг үнэлэх зорилгоор аттестатчиллыг 5 жил тутамд Хэмжил зүйн төв байгууллага зохион байгуулна.

4.2 Улсын шалгагч нь эрх олгосон хэмжлийн төрөл тус бүрээр аттестатчилалд хамрагдах бөгөөд хүндэтгэн үзэх шалтгаанаар хамрагдаагүй бол нөхөж хамрагдана.

4.3 Аттестатчилал хоорондох хугацаанд 60-аас доошгүй цагийн хэмжил зүйн болон эрх олгосон хэмжлийн төрлөөр сургалтад хамрагдсан улсын шалгагчийг аттестатчилалд хамруулна.

4.4 Аттестатчиллын ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг Хэмжил зүйн төв байгууллагын даргын тушаалаар 45-аас доошгүй хоногийн өмнө 9-өөс доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байгуулна. Ажлын хэсгийн ахлагч нь Хэмжил зүйн төв байгууллагын Төрийн захиргааны асуудал хариуцсан нэгжийн дарга байна.

4.5 Ажлын хэсгийн гишүүдийг тухай бүрд томилох бөгөөд хэмжил зүйн салбарт тасралтгүй 5-аас доошгүй жил ажиллаж байгаа, дадлага туршлагатай, мэргэшсэн ажилтан байна

4.6 Ажлын хэсэгт салбарын хэмжил зүйн байгууллагуудын төлөөллийг оролцуулж болно.

4.7 Ажлын хэсгийн бүрэлдэхүүний дийлэнх олонхи хуралдсан тохиолдолд шийдвэр хүчинтэй байна.

4.8 Ажлын хэсэг дараах эрх, үүрэгтэй. Үүнд:

4.8.1 Онолын мэдлэгийн шалгалтын тестийг бэлтгэх, нууцлалыг хангах;

4.8.2 Онолын мэдлэгийн болон ур чадварын шалгалт авах, ярилцлага хийх;

4.8.3 Аттестатчиллын дүнг нэгтгэн гаргах, холбогдох шийдвэр гаргуулах;

4.8.4 Аттестатчилалтай холбоотой гомдол, маргааныг шийдвэрлэх;

4.9 Ажлын хэсэг нь ажлын 22-оос доошгүй хоногийн өмнө Аттестатчиллын ажлыг зохион байгуулах төлөвлөгөө, удирдамжийг боловсруулан Хэмжил зүйн төв байгууллагын даргаар батлуулж, аймаг, нийслэлийн хэмжил зүйн байгууллага, хэмжил зүйн мэргэжлийн байгууллагуудад хүргүүлнэ.

4.10 Хэмжил зүйн төв болон аймаг, нийслэлийн хэмжил зүйн байгууллага, хэмжил зүйн мэргэжлийн байгууллагын дарга аттестатчилалд хамрагдах улсын шалгагчдын ажил байдлын тодорхойлолт, ямар хэмжлийн төрлөөр аттестатчилад орох зэрэг мэдээллийг аттестатчилал хийгдэхээс ажлын 10-аас доошгүй хоногийн өмнө журмын нэгдүгээр хавсралт маягтын дагуу гаргаж ажлын хэсэгт ирүүлнэ.

4.11 Улсын шалгагч нь мэдлэг, ур чадвараа байнга дээшлүүлж байх бөгөөд нөхцөл боломжийг харьяалах байгууллага нь хангаж өгнө.

4.12 Ажлын хэсэг нь аттестатчиллын дүнг энэ журмын 3.8.2-т заасан хүснэгтийн дагуу үнэлнэ.

4.13 Аттестатчиллын ажлын хэсэг нь улсын шалгагчдаас MNS OIML D 14 стандартын 4.2-д заасан сургалтын сэдэвчилсэн төлөвлөгөөний агуулгад нийцсэн хууль эрх тогтоомж, хэмжил зүйн ерөнхий болон тухайн хэмжлийн онолын мэдлэгийн шалгалтыг тестээр авна. Шалгалтын асуултыг тухайн жилдээ товхимол байдлаар бэлтгэн гаргана.

4.14 Шалгалтын явцад сургалтын материал, гарын авлага, бусад материалыг ашигласан, хуулсан зэрэг зөрчил гаргасан улсын шалгагчийг шалгалтаас хасаж, дүнг хүчингүйд тооцно.

4.15 Шалгалтын тест бэлтгэсэн болон хадгалж байгаа ажилтан тест задруулахыг хориглоно.

4.16 Ажилтан онолын мэдлэгийн шалгалтад босго онооны шаардлагыг хангасан бол мэргэжлийн ур чадварын шалгалтыг, мэргэжлийн ур чадварын шалгалтыг, ур чадварын шалгалтад 21 ба түүнээс дээш оноо авсан бол ярилцлагын шалгалтыг тус тус өгнө.

4.17 Ур чадварын болон ярилцлагын шалгалтад тухайн шалгалтыг авч буй бүрэлдэхүүн оноо өгөх бөгөөд гишүүн тус бүрийн өгсөн онооны арифметик дундажийг журмын зургаадугаар хавсралт маягтын дагуу гаргана.

4.18 Улсын шалгагч хэд хэдэн хэмжлийн төрлөөр аттестатчилалд орсон тохиолдолд хууль тогтоомж, хэмжил зүйн ерөнхий онолын мэдлэгийн шалгалтыг нэг удаа тестээр өгөх бөгөөд аттестатчилалд орох хэмжлийн төрөл тус бүрээр тухайн хэмжлийн онолын мэдлэгийн шалгалт, ур чадварын шалгалтыг өгнө. Аттестатчиллын ажлын хэсэг хэмжлийн төрөл тус бүрээр үнэлгээ өгч дүгнэлт гаргана.

4.19 Хэмжүүрийн улсын шалгагчид нийлбэр оноогоор нь дараах үнэлгээ өгнө.

- (60 ба түүнээс дээш) Хангалттай

- (59 ба түүнээс доош) Хангалтгүй

4.20 Аттестатчиллын үнэлгээг улсын шалгагчид танилцуулж, тэнцсэн бол аттестатчиллын гэрчилгээ олгох бөгөөд түүний хуулбарыг хувийн хэрэгт хадгална.

4.21 Аттестатчилал хоорондын хугацаанд шинээр эрх авсан, аттестатчилалд тэнцсэн улсын шалгагчийн эрх нь дараагийн аттестатчилал хүртэл хүчинтэй байна.

4.22 Аттестатчиллын үед хүүхэд асрах чөлөөтэй, байгууллага дотроо өөр албан тушаалд томилогдон ажиллаж байсан улсын шалгагч буцаж ажилдаа томилогдсон бол сургалтад хамруулахгүйгээр энэ журмын 3.8.2-д заасан шалгалтыг авч улсын шалгагчийн эрхийг сэргээн олгож болно.

4.23 Улсын шалгагч аттестатчилал, түүний үнэлгээ, дүгнэлтийн талаар ажлын хэсэгт гомдол гаргаж болох бөгөөд гомдлыг ажлын хэсэг ажлын 5 хоногийн дотор шийдвэрлэнэ.

4.24 Аттестатчилалд Хангалттай үнэлгээ авсан улсын шалгагчийн цалингийн сүлжээний шатлалыг ахиулан олгож болох бөгөөд үүнийг харьяалах байгууллагын дарга шийдвэрлэнэ.

4.25 Давтан аттестатчилалд тэнцсэн улсын шалгагчид энэ журамд заасны дагуу аттестатчиллын гэрчилгээ олгож, эрхийг сэргээнэ.

Тав. Улсын шалгагчийн эрхийг түдгэлзүүлэх, цуцлах

5.1 Давтан аттестатчилалд тэнцээгүй улсын шалгагчийн эрхийг түр түтгэлзүүлэх бөгөөд улсын шалгагч 3 сарын дотор 1 удаа дахин аттестатчилалд орж болно.

5.2 Дараах тохиолдолд улсын шалгагчийн эрхийг цуцална. Үүнд:

5.1.1 Ажлаас халагдсан, чөлөөлөгдсөн;

5.1.2 Аттестатчилалд хамрагдаагүй, тэнцээгүй;

5.3 Давтан аттестатчилалд тэнцээгүй хэмжүүрийн улсын шалгагчийн эрхийг Хэмжил зүйн төв байгууллагын даргын тушаалаар цуцалж, энэ талаар харьяалах байгууллагад нь мэдэгдэнэ.

Зургаа. Хүлээлгэх хариуцлага

6.1 Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу эрх бүхий албан тушаалтан хариуцлага хүлээлгэнэ.

Улсын шалгагчид эрх олгох, түүнийг
аттестатчилах журмын 1 дүгээр хавсралт

**Улсын шалгагчийн
ажил байдлын тодорхойлолтын маягт**

1. Овог. Нэр:
2. Харьяалагдах байгууллага, лабораторийн нэр:
3. Төгссөн сургууль (хэзээ хаана, ямар сургууль төгссөн):
4. Сургуулиар эзэмшсэн мэргэжил:
5. Ажилласан нийт хугацаа (жил):
6. Хэмжил зүйн салбарт ажилласан хугацаа (жил):
7. Аттестатчилалд орох хэмжлийн төрөл, энэ хэмжлийн төрлөөр ажилласан хугацаа
(жил):
8. Өмнө нь аттестатчилалд орж байсан эсэх, орж байсан бол аттестатчилапын
гэрчилгээний хуулбарыг хавсаргах:
-
9. Сүүлийн 2 жилд сургалтад хамрагдсан байдал (цаг, огноо), гэрчилгээний
хуулбарыг хавсаргах:
-
10. Сүүлийн 2 жилд хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын ажил гүйцэтгэсэн
байдлын талаарх товч тодорхойлолт, ажлын дэлгэрэнгүй тайланг хавсаргах:
-

Тамга

Тодорхойлолт гаргасан:

/Харьяалах байгууллагын дарга/

Огноо

**Хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтын ажлын ур чадварын
шалгалтын дүнгийн хуудсын маягт**

1. Овог, нэр:

2. Харьяалагдах байгууллага, лабораторийн нэр:

3. Ажлын хэсгийн гишүүд:

- Овог нэр, албан тушаал
- Овог нэр, албан тушаал
- Овог нэр, албан тушаал

4.загварын ажлын эталон хэмжих хэрэгсэл ашиглан
..... загварын..... анги, нарийвчлал,..... хэмжих
хязгаартайдугаартай
хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын ажлыг
..... улсын стандарт, аргачлалын дагуу гүйцэтгэсэн
байдалд дараах ур чадварын шалгалт хийв. Үүнд:

4.1 Хэмжил зүйн ажил, үйлчилгээ эрхлэх чадавхаа үнэлүүлсэн байдал,
хэмжих хэрэгслийн улсын бүртгэл, баталгаажуулалтад ашиглаж байгаа ажлын
эталон хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга, улсын баталгаажуулалтад заавал
хамруулах хэмжих хэрэгслийн жагсаалтын талаарх мэдлэг (5 оноо)

.....
.....

4.2 Хэмжих хэрэгслийг холбогдох улсын стандарт, аргачлалын дагуу
шалгаж баталгаажуулж байгаа байдал (25 оноо):

4.3 Хэмжлийн үр дүнг тооцсон, баталгаажуулалтын гэрчилгээ болон хэмжих
хэрэгслийг ашиглалтаас хасах тухай мэдэгдлийн бичилтийн байдал (5 оноо):

.....

5. Ур чадварын шалгалтад өгсөн оноо (35 оноо) :

6. Хэмжих хэрэгслийн шалгалтын тайланг хавсаргана.

Шалгалтад хамрагдсан:

Хэмжүүрийн улсын шалгагч

Шалгалт авсан ажлын хэсэг:

Овог нэр, албан тушаалц
Овог нэр, албан тушаал
Овог нэр, албан тушаал

огноо

Улсын шалгагчид эрх олгох, түүнийг
аттестатчилах журмын 3 дугаар хавсралт

ХЭМЖИЛ ЗҮЙН ТӨВ БАЙГУУЛЛАГЫН НЭР

УЛСЫН ШАЛГАГЧИЙН
АТТЕСТАТЧИЛЛЫН ГЭРЧИЛГЭЭ

.....
(Харьяалах байгууллага, лабораторийн нэр)

..... нь

(овог, нэр)

Улсын шалгагчийн оны аттестатчилалд хамрагдаж

1. хэмжлийн төрлөөр
.....
(аттестатчиллын үнэлгээ)
2. хэмжлийн төрлөөр
.....
(аттестатчиллын үнэлгээ)
3. ... хэмжлийн төрлөөр
.....
(аттестатчиллын үнэлгээ)

үнэлгээ авч АТТЕСТАТЧИЛАЛД ТЭНЦСЭН тул аттестатчиллын гэрчилгээг олгов.

Энэ аттестатчиллын гэрчилгээ нь дараагийн аттестатчилал хүртэл хүчинтэй.

Тамга

Аттестатчиллын ажлын хэсгийн ахлагч:
ажлын хэсгийн гишүүд:

Огноо

Улсын шалгагчид эрх олгох, түүнийг
аттестатчилах журмын 4 дүгээр хавсралт

Улсын шалгагчийн эрхийг шинээр олгох
шалгалтын дүнгийн хуудасны март

№	Харьяалах байгууллага, лабораторийн нэр	Эрх олгох ажилтны овог нэр	Эрх олгох хэмжлийн төрөл	Онголын мэдлэгийн шалгалт			Ур чадварын шалгалт (35 оноо)	Ярилцлага (10 оноо)	Нийлбэр оноо (100 оноо)	Дүгнэлт
				Хууль эрх зүй (15 оноо)	Хэмжил зүйн ерөнхий (20 оноо)	Эрх олгох хэмжлийн (20 оноо)				

Эрх олгох ажлын хэсгийн ахлагч:
ГШИҮҮД:

Дүнг нэгтгэсэн:

Огноо

Улсын шалгагчид эрх олгох, түүнийг
аттестатчилах журмын 5 дугаар хавсралт

Өөр хэмжлийн төрлөөр улсын шалгагчийн
эрх нэмж олгох шалгалтын дүнгийн хуудасны маягт

№	Харьяалах байгууллага, лабораторийн нэр	Эрх олгох ажилтны овог нэр	Эрх олгох хэмжлийн төрөл	Эрх олгох хэмжлийн онол (20 оноо)	ур чадварын шалгалт (35 оноо)	Ярилцлага (10 оноо)	Нийлбэр оноо (65 оноо)	Дүгнэлт

Эрх олгох ажлын хэсгийн ахлагч:
гишүүд:

Дүнг нэгтгэсэн:

Огноо

Улсын шалгагчид эрх олгох, түүнийг
аттестатчилах журмын 6 дугаар хавсралт

Улсын шалгагчдын оны аттестатчиллын
дүнгийн хуудасны маягт

№	Харьяалах байгууллага, лабораторийн нэр	Улсын шалгагчийн овог, нэр	Аттестатчилалд орох хэмжлийн төрөл	Онолын мэдлэгийн шалгалт 55 оноо			Ур чадварын шалгалт (35 оноо)	Ярилцлага (10 оноо)	Нийлбэр оноо (100 оноо)	Үнэлгээ (А, В, С, D, F)
				Хууль эрх зүй (15 оноо)	Хэмжил зүйн ерөнхий (20 оноо)	Эрх олгох хэмжлийн (20 оноо)				

Эрх олгох ажлын хэсгийн ахлагч:
гишүүд:

Дүнгийн нэгтгэсэн:

Огноо

Улсын шалгагчид эрх олгох, түүнийг
аттестатчилгах журмын 7 дугаар хавсралт

Улсын шалгагчийн бүртгэлийн маягт

№	Харьяалах байгууллага, лабораторийн нэр	Эрх олгох ажилтны		Эрх олгосон хэмжлийн төрөл	Улсын шалгагчийн хувийн дугаар	Эрх олгосон тушаалын дугаар
		овог	нэр			

Нэгжийн дарга:

Бүртгэл хөтөлсөн:

Огноо